

Энэхүү өгүүлэлийг ОХУ-ын нэрт түрэгч Эдхям Рахимович Тенишев (1921-2004)  
профессорын гэгээн дурасхалд зориулав.

Түүхэн хэлшинжлэлийн судлагааны  
аргазүйд анхааруштай зарим зарчимын тухай

Ц. Шагдарсүрэн (МУИС)

Үүнээс өмнө, аргазүйн энэхүү асуудалыг монгол-алтай хэлний харьцуулсан судлагаа<sup>1</sup> болон үсэг бичигийн түүхэн харилцааны<sup>2</sup> хүрээнд энэ сэдвийг хөндөн ярьсанаас гадна монгол хэлний үг бүтэх ёсонтой холбон үзсэн<sup>3</sup> удаа бий.

Тэгэхдээ энд өгүүлэх гэж буй “аргазүй” (methodology)-н зарчим нь шинжлэх ухаанд цоо шинэ юм огт биш, үүнээс өмнө эрдэмтэдийн тэмдэглэн сануулсан зүйл буй<sup>4</sup> ч, уг зарчим монгол хэлбичигийн ухааны түүхэн судлагааны олон салбарт чамлалтай байгааг сануулахын хажуугаар тэрхүү аргазүйг хэрэглэх бөгөөс эрдэм шинжилгээний ажил улам боловсронгуй болох, түрүү түрүүчийн судлагааны үр дүнг хэлшинжлэлийн онолын үүднээс баримт тогтолцоотой батадхах, эсвэл баримт тогтолцоотой эргэлзүүлэх бололцоог олгоно гэж итгэж байна. Бас судлагчидын санал хуваагдсан маргаантай зүйлийг ац хагалан зөв шийдэхэд ч чухаг баримжаа хэмжүүр болж өгөх нь дамжиггүй.

Алтай овогийн бусад хэл хийгээд монгол хэлний харилцаа холбоо, бичиг үсэгийн харилцан нөлөөлсөн байдал, монгол хэлний үг бүтэх ёсон, түүний хөгжиж ирсэн зам чийрийг судлахад аргазүйн зарчим болон хувь хүний онцлогоос хамаарч судлагааны үр дүнд сөрөгөөр нөлөөлөхүйц хүчин зүйл байгааг үгүйсгэх аргагүй юм. Дээрхи салбараар гарсан нэг бус зохиол бүтээлийг үзвэл судлагааны аргазүйн хувьд:

<sup>1</sup> Ts. Shagdarsürüng, *Problems of Methodology of Altaic Comparative Linguistics*, - Rocznik Orientalistyczny, Tom. LVIII, Zeszyt 1 (Opera Altaistica professori Stanislawo Katuszynski octogenario dicata), Warszawa, 2005, pp. 179-187; Ц. Шагдарсүрэн, *Монгол хэлний хөгжлийн эртний үе, түүнийг судласан тойм*, - Эртний монгол хэлний судлал (Монголын судлалын сонгомол өгүүлэлийн эрхи, I хэлмэли: Монгол хэл, II дэвтэр), Улаанбаатар, 1999, (67-125) 72-73-р тал;

<sup>2</sup> Ts. Shagdarsürüng, *A Study of the Relationship Between the Korean and the Mongolian Scripts*, - Mongolian Studies (Journal of the Mongolia Society [of USA]), Volume XXV (2002), Bloomington, Indiana, pp. 59-84.

<sup>3</sup> Ц. Шагдарсүрэн, *Монгол бичигийн хэлний [V+yi+C / CV +yi+ C] бүтэцийг галиглах асуудалд* - Дундад Улсын Монгол судлалын Олон улсын ярилцах хурал (2005 оны 8-р сарын 19-23, Хөх хот)-д зориулж бичсэн илтгэл - *Үндэсний монгол судлал*, N. 6, 2005, Улаанбаатар, 34-37-р тал; Ц. Шагдарсүрэн, *Эх хэлээ эвдэхгүй юм сан...*, Улаанбаатар, 2007, 162-163, 166-167-р тал.

<sup>4</sup> Andras Rona-Tas, *On the Meaning of "Altaic"*, - Tractata Altaica, Wiesbaden, 1976, pp. 549-556

1. Аливаа харьцуулагдахууны агуулгын тал буюу дотоод (ялангуяа далд) тогтолцоог нь орхигдуулан зөвхөн гадаад хэлбэрт түлхүү анхаарсан;

2. Зөвхөн өнөөдөрийн яс тохироог чухалчилаж, тухайлбал: нэг овогт багтах хэлнүүдийн түүхэн харилцааны хувьд тухайн үгийн утгын орон (Semantic field / семантическое поле)-ыг төдий л анхааралгүй, зөвхөн толь бичигийн толгой үгийн орчуулга төдийгөөр хязгаарласан;

3. Хэлийг харьцуулан судлахад түүхэн үеийн турши дахи, нэгэн гаралаас салаалан хөгжисөн эсэх, тодорхой үед нэг хэлнээс нөгөө хэлэнд үг орох, санамсаргүй төс, эсбөгөөс гарал нэг бус гэх зэрэг хөгжилийн өөр өөр зам мөрийг үл харгалзсан, түүнчилэн тухайн судлагч хувийн үзэл баримтлал хийгээд ямар нэгэн далд сонирхолдоо хөтлөгдсөн;

4. Хэлний дотоод хөгжилийн хүрээнд, үг бүтэх ёсны түүхэн бодот хөгжилийг үе шатаар нь тооцохоосоо илүү, монгол хэлний мөн чанарыг хангалттай тусхаж чадаагүй шинэ үсэгийн дүрэмээр бичиж байгаа өнөөдөрийн хэлбэрт хэт шүтэж түүхэн баримтыг хангалтгүй буюу үл харгалзсан;

5. "Хэл – тогтолцоо" гэдэг зарчмыг анхаараагүй буюу тухайн нэг судлагдахууныг хэлний зохих төвшин төвшинд нь авч үзэхгүй байх, судлагдахууныг өөр өөр төвшинөөс үзэх ёстой асуудалыг хольж хутган аль нэгэнд нь хүчээр нялзаах, эсвэл цуваа цагийн судлагдахууныг хам цагийн үүднээс тайлбарласан...

6. Монгол бичигийн хэлний онцлог хийгээд монгол бичигээр уламжилан ирсэн түүхэн тэмдэглэгдэхүүнийг төдий л анхаараагүйгээс үүдэж монгол хүний хэл-сэтгэлгээний холбоог буруу тайлбарлах, судлагааны чухаг баримт сэлтийг орхих ...

зэрэг нь судлагааны эцэсийн дүгнэлтэд сөрөг нөлөө үзүүлэхэд хүрч байна. Ийнхүү тав хуваасан нь тайлбарлахад ойлгомж хязгаартай болгож байгаагаас биш хоор зуураа огт холбоогүй гэсэн үг бас биш.

Үүний дээр тухайн судлагчийн хувийн үзэл бодол хийгээд шимтэн судласан зүйлдээ хайртай болж, уламаар тэр судлагдахуунаа бусад зүйлийн дээр тавьж, бүхэний анхдагч болгохыг эрмэлзэх зэрэг хүмүүний араншинг бас үгүйсгэх аргагүй. Нэг бус тохиолдолд хүмүүний энэ мэт араншингийн цаана улс төр, цагийн байдалыг дагасан өнгө аяс ил далд явж байдагийг ч нуух хэрэггүй.

Дараа тусхайлан нэгэн өгүүлэл бичих санаатай учир, энэ удаад хувь хүний үзэл болон түүний цаана байж болдог улс төрийн өнгө аясыг орхиж, цэвэр судлагааны аргазүйн зарчимд хамаарах зарим зүйлийг дээр дурадсан дараалалаар арай тодруулахыг хичээв. Тэгэхдээ энд хэн нэгэн судлагчийн зарим эргэлзээтэй маргаантай байж болзошгүй тодорхой дүгнэлтийг шууд үгүйсгэх, буруутгах эсвэл батлах гэсэн явдал огт байхгүй, магадгүй тийм байж болох ч холбогдох бусад баримтыг нэгэн цогц болгон өргөн хүрээнд хөгжилийн явц, судлагааны төвшин (англи: *hierarchy*, орос: *уровень / ярус*) хийгээд орон зай, цаг хугацааны хамаарал тэргүүтэнийг хамруулан бодолцож гэмээ нь тухайн дүгнэлт улам баттай болж чадах эсэхэд л хэрэгийн гол учир буй гэдэг гол зарчмыг баримтласан болно. Энэхүү нэгэн өгүүлэлийн хэмжээнд хэд хэдэн асуудалыг

хөндөх тул түрүү нийтлүүлсэн ном, өгүүлэлд авсан жишээ баримтыг товчилон ашигласан минь цааш нь дэлгэрүүлэн үзэх боломжийг давхар бодолцсон хэрэг.

1. Харьцуулсан судлагааны хувьд зөвхөн гадаад хэлбэрийг голлоод, дотоод тогтолцоог зохих ёсоор анхаараагүй буюу орхигдуулсан явдал үсэг бичигийг харьцуулан судлах явцад түлхүү харагддаг. Үүнд: солонгос бичиг зохиоход анхаарсан гэх онолын нэгэн баримтлалыг жишээ болгон үзэе<sup>5</sup>. Солонгосын *Hunmin chōng'üm* (訓民正音) бичигийг монгол туургатаны хэрэглэж ирсэн үсэг бичигтэй харьцуулсан нэг бус судлагааг үзэхэд гадаад хэлбэрийн хувьд монгол бичиг болон монголын дөрвөлжин бичигтэй ойр төстэй гэдэг талаас нь түлхүү анхаарч ирсэн зүйл бий. Үүнийг гадаад төсийн хувьд үгүйсгэх аргагүй ч улам батлагаатай болгоход уг бичигийг анх зохиох үеийн "*Hunmin chōng'üm haerye*" (訓民正音解例 "*Explanation and Examples for the Hunmin chōng'üm*") хэмээх тайлбар сэлтэд нь дурадсан дотоод тогтолцоо буюу хэлшинжлэлийн онолын баримтлалыг нь анхаарах бөгөөс нэг бус зүйл улам тодрох боломжтой болно. Тухайлбал: тэрхүү тайлбарт үеийн тогтолцоог *эхин, дунд, адаг* хэмээх "гурван байрт онол" (*tripartite theory*)-оор тайлбарласан байдаг ажээ. Жишээ нь: *ᠠᠯ* [*kak*] буюу 'эвэр' гэдэг үгийг [*k-a-k*] гэсэн гурван бүтэцтэй гэж үзээд

[*k-*] нь *эхин* [the initial "*k-*" or the *onset*],  
[*-a-*] нь *дунд* [the medial "*-a-*" or the *peak*],  
[*-k*] нь *адаг* [the final "*-k*" or the *coda*]

хэмээн тайлбарлажээ. Ийнхүү хуваасан нь энэдхэг-төвөдөөс гаралтай, монгол бичигийн уламжилалд илүү ойрхон тайлбар гэсэн үг. Хэрэвзээ нангиадын хэлшинжлэлийн уламжилалаар тайлбарласан бөгөөс *эхин, адаг* гэсэн "хоёр байрт онол" (*bipartite theory*)-ыг баримтлан "*k-ak*":

[*k-*] нь *эхин* [the initial],  
[*-ak*] нь *адаг* [the final]

гэж хоёр хуваах байсан бөлгөө. Ийнхүү ханз бичигийг хэрэглэж байх үед онцгой нөлөөтэй байсан "хоёр байрт онол"-ыг шинэ тулгар зохиосон үндэсний бичигтээ уламжилан авч хэрэглээгүй нь юуны өмнө, хэвшинж(the typology)-ийн хувьд залгамал солонгос хэл нь тусхайлиг хэвшинжтэй хятад хэлтэй огт адилгүй, хоёрт, шинэ боловсруулсан *Hunmin chōng'üm* хэмээх бичиг нь цагаан толгойт авианы бичиг болохын хувьд хятадын дүрс бичигтэй адилгүй байсантай холбоотой гэж үзэх хэлшинжлэлийн үндэслэлтэй холбоотой юм. Хэдий тийм боловч дээр дурадсан тайлбар номд үеийн тогтолцоог тийнхүү гурав хуваасан онол(*tripartite theory*)-ын үндэслэлээ тодорхой дурадсангүй нь тухайн үед гадаад харилцааны хувьд нангиадын улс төрийн нөлөө үлэмж хүчтэй, дотоодтоо нангиадын уламжлалыг даган баримтлах хүчин нөлөө их байсантай холбоотой гэж судлагчид онцлон тэмдэглэсэн байдаг.

Энэ мэтээр судлагдахууны гадаад өнгөн төсийн хажуугаар онолын дотоод баримтлалыг нь давхар анхаарч гэмээ нь судлагааны эцэсийн дүн, батлагаа улам нарийсан тодрох нь дамжиггүй юм.

2. Нэг овогт багтах, тухайлбал: Алтай овог хэлнүүдийн харьцуулсан судлагааны зарим үр дүнг харахад орчин цагийн толь бичиг дэхи толгой үгийн утгыг түлхүү анхаарсан байдаг нь хэлний цуваа цагийн хөгжилийн баримт хийгээд тухай тухайн хэлний бие даан салаалан хөгжсөн зам чийрийг хангалттай харгалзаагүй, мөн утгын

<sup>5</sup> Ts. Shagdarśürting, *A Study of the Relationship Between the Korean and the Mongolian Scripts*, - Mongolian Studies (Journal of the Mongolia Society [of USA]), Volume XXV (2002), Bloomington, Indiana, pp. 59-84.

орон (Semantic field)- ыг зохих ёсоор анхаараагүй юм биш байгаа, энэ нь судлагаана эцэсийн дүн сөрөгөөр нөлөөлөхөд хүрч байна гэдэг бодол төрүүлдэг. Монгол түрэг хэлний зарим үгээр жишээ аван тодруулахыг хичээе. Монгол хэлний *чих, цус, шавар, сүх* гэх зэрэг олон үгийг орчин цагийн түрэг хэлний толь бичиг дэхи тухайн утга илэрхийлэх толгой үгтэй харьцуулан үзэхэд, (бүдүүн тоймоор тэмдэглэж гэмээ нь) *чих* – *кул* ~ *хул*, *цус* – *кан* ~ *хан*, *шавар* – *балчык*, *сүх* – *балта* гэх зэргээр хэлбэрийн хувьд тохирдоггүй. Энэ мэт олон үг нь Алтай хэлний гарал үүсэлд эргэлзэх нэгэн шалтгааныг нөхцөлдүүлдэг тал буй. Гэвч тухай тухайн үгийн утгын ороныг харгалзах бөгөөс өөр дүгнэлт гарахыг үгүйсгэх аргагүй. Монгол хэлнээ *хулгар, хулхи, хулмай*- гэх зэрэг *чих*-тэй шууд холбоотой, *цус хана*- гэхэд хэрэглэгддэг *хана*- нь *цус*-тай шууд холбоотой, *намаг балчиг, шавар балчиг, балчигт шигдэ*- гэдэг хэлэлгэд буй *шавар*-тай шууд холбоотой, хангинуур сүхээс ялгаж *балт* гэдэг үг монгол хэлэнд буйн дээр зарим нутагт *сүх*-ийг *балт* хэмээдэг гээд энэ мэт олон үг байгааг үгүйсгэх аргагүй.

Иймэрхүү жишээ зөвхөн монгол түрэг хэлний тухайд биш, Алтай овогийн бусад хэлнээ, тухайлбал: монгол хэлний *хаши*- гэдэг үгтэй утга хийгээд хэлбэрийн хувьд дүйх үг япон хэлэнд “*hashi*” – савх гээд байж байгаа, монгол хэлний \**nindun* гэдэг эртний хэлбэрээс үүссэн “нүд” гэдэг үг одоо солонгост “*nun*”, эвэнкэд “*nundun*” гэдэг хэлбэрээр байдагийг хэлж болно.

Энэ бүхэн нь Алтай овог хэлний нийтлгийн асуудалыг тодруулах баримт болохоос биш зарим хүний үздэгчилэн монгол хэлнээс орсон гэж монгол төвт үзэлийг баримтласан хэрэг огт биш.

3. Монгол хэлний “*цэрэг цуух*” гэдэг холбоо үгийн “*цуух*”-ыг цэрэг гэсэн утга бүхий манж үг гэж үздэг нь маргаангүй боловч цааш нь лавшируулан үзэх олон зүйл бий гэж боддог. “*Монголын нууц товчоон*”-д *довтлох, дайрах* гэсэн утга бүхий *ца’ур* *ца’ура*-, *ца’уру’ал*- гэдэг үг гардаг. Бас Лувсанданзаны “*Алтан товч*”-ид “...*Basa Qubilai noyan-i Qarluyud-dur cayerayulbai*...” гэсэн хэсэг бий бөгөөд *cayerayulbai* гэдэг үгийн хажууд утгы нь тодруулж *ceriglegülbei* хэмээн нэмж бичсэн нь буй. Бас “*Хуа-и-юй*” толь хятад үсэгээр галигласан монгол үгийн дотор энэ үг мөнөөхи утгаараа *ца’ура* ~ *cawura* (хятад галигаар: ch’ao-wu-erh) гэдэг хэлбэрээр тохиолддог байна<sup>6</sup>.

Зөрчидөч япон эрдэмтэн Г. Н. Кийосэ (G.N.Kiyose), орос эрдэмтэн А. М. Певнов нарын судлагаанаас үзэхүл зөрчид хэлнээ *цэрэг* гэсэн утга бүхий “*cauha*” гэдэг үг байдаг ажээ<sup>7</sup>. Зөрчид хэлний энэ хэлбэрийг манж хэлний *цэрэг* гэсэн утга бүхий \* $\sqrt{ca}u$  +  $\chi(a)$  > \* $\sqrt{ca}’u$  +  $\chi(a)$  > *sooha* гэдэг үгийн гаралтай холбож үзэх бүрэн үндэс буй.

<sup>6</sup> Ts. Shagdarsürüng, *Problems of methodology of Altaic comparative linguistics*, - Rocznik Orientalistyczny, Tom. LVIII, Zeszyt 1, Warszawa, 2005, (pp. 179-187) see p181; Hitoshi Kuribayashi, *Word- and Suffix-Index to Hua-yi Yi-yu...*, Tohoku University, Sendai, 2003, pp. 74, 126.

<sup>7</sup> G.N. Kiyose, *A Study of the Jurchen Language and Script*, Kyoto, 1977, pp. 112, 114; А. М. Певнов, *Чтение Чжуржэньских писем*, (РАН, Институт Лингвистических Исследований), Санкт-Петербург, 2004, стр. 498 - [A. M. Pevnov, *The Jurchen Script, Grammatological Principles and Linguistic Results of Phonoverified Reading*, (Russ. Academy of Sciences, Institute for Linguistic Studies) St. Peterburg, NAUKA, 2004, 498 p.], См. стр. 350.

Дундад үеийн монгол болоод зөрчид хэлнээ энэ язгуур үг үлэмж идэвхитэй хэрэглэгдэж байсаныг дээрхи олон баримт гэрчилээд зогсохгүй Зөрчидийн Алтан улсаас Чингис хаанд өгсөн *ca'ut-quri* гэдэг цол ч бидний өгүүлэн буй \**ᠴаγи* язгууртай утгын хувьд ч, хэлбэрийн хувьд ч холбоогүй гэж үзэх арга байхгүй.

Орчин цагийн монгол хэлэнд \**ᠴаγи +r (a)* үндэсээс салбарлан хөгжисөн үг ялангуяа ярианы хэлнээ, тухайлбал: халхын аялгуунд “буу цоор болсон олон хүн явна” гэдэг жишээнд буй “цэрэг зэвсэг”-т холбогдох утга бүхий *tsōr* гэдэг үг ордосын аялгуунд *cirik cūr* гэдэг жишээнд *tsūr*, буриадын аялгуунд *sereg sūr* гэдэг жишээнд *sūr* гэдэг хэлбэрээр одоо болтол байсаар байгааг А. Мостаер, Н. Поппе нарын судлагаа болон буриад хэлний толь бичигүүд давхар батлаж байна<sup>8</sup>.

Монгол хэл, аялгуу хийгээд зөрчид, манж хэлэнд буй дээрхи бүх баримт нь Алтай овог хэлний нийтлэгт хамаарна гэж үзэх боломжийг харуулж байна. Энэ нь Алтай хэлний \**ᠴаγи* хэмээх нийтлэг язгуураас манж хэлний бие даасан хөгжилийн үр дүн болсон \**ᠴаγи + χ(a) > сооха* гэдэг үг түүхэн тодорхой нөхцөлд монгол хэлнээ *чуух(a)* гэдэг хэлбэрээр орсонг үгүйсхэх шалтгаан болохгүй.

Үүнтэй холбон нэмэхэд, бидний өгүүлэн буй энэ зарчимд гарал нэг хэлнүүдийн салбарласан хөгжилийн үр дүнд буй болсон “далд” тохироог харгалзахгүй байхын аргагүй. Тухайлбал: монгол хэлний *ji-* хэмээх бүтэц нь зөрчид, хамниган, манж хэлний *ni-* бүтэцтэй олон нөхцөлд тохирдог бөгөөд үүний дүнд монгол хэлний *jirγuγan* “зургаан”, *jigasun* “загас”, *jiruγ* “зураг” гэх зэрэг олон үг манж хэлнээ *ninggūn*, *nimaχa*, *nirūgan*, зөрчид хэлнээ *nilhun* “арван зургаа” гэж тогтолцоотой тохирдогийг судлагчид хэдийнээ тогтоожээ<sup>9</sup>. Цаашид энэ мэт “далд” тохироог зөвхөн монгол, хамниган, манж хэлээр хязгаарлалгүй түрэг, солонгос, япон зэрэг Алтай овогийн бусад хэлнээс нээн тодруулах шаардалга бидэнд бий. Энэ талаар профессор Ш. Озава тусхайлан судлаж, сүүлийн үед оросын эрдэмтэн С. А. Старостин, А. А. Бурыкин нар судлагаандаа багагүй анхаарч байна<sup>10</sup>.

4. Орчин цагийн монгол хэлнээ *эгшиглэн, залилан, нягтлан* гэх зэрэг –*лан* дагавартай хэсэг нэр үг идэвхитэй хэрэглэгдсээр байгаа бөгөөд оросжин кирилл шинэ бичигээр буй гадаад хэлбэрээс нь үзэхүл цөм –*лан* төгөгсөлтэй үг мэт харагдана. Тэгээд зарим судлагч дээрхи үгийг гадаад хэлбэрээс нь хам утга бүхий нөхцөл үйл үг тул нэр үгийн үүргээр хэрэглэх нь

<sup>8</sup> N. Poppe, *Ancient Mongolian*, - Tractata Altaica, Wiesbaden, 1976, p. 463.

<sup>9</sup> B. Laufer, *Jurci and Mongol numerals* – Korosi Csoma Archivum, Vol. 1-2, Budapest, 1921, pp. 112-115; N. Poppe, *Ancient Mongolian*, - Tractata Altaica, Wiesbaden, 1976, p. 463-478; N. Poppe, *Jurchen and Mongolian*, - Studies on Mongolia (Proceeding of the North American Conference on Mongolian Studies, 1978) editor H. G. Schwarz, Western Washington University, 1979, pp. 30-37; Ц. Шагдарсүрэн, *Монголчуудын утга соёлын товчоон*, Улаанбаатар, 2003, 255-256-р тал.

<sup>10</sup> Ш. Озава, *Монгол япон хэлний холбоо*, ОУМЭ-ий IV Их хурал, II боть, Улаанбаатар, 415-420-р тал; С. А. Старостин, *Алтайская проблема и происхождения Японского языка*, Москва, 1991; А. А. Бурыкин (С-Петербург), *Монгольская лексика в текстах-образцах малого чжурчжэньского письма*, - Проблемы истории и культуры кочевых цивилизаций Центральной Азии, Языки, фольклор, литература, Улан-Удэ, 2000, стр. 52-55; А. А. Бурыкин, *Роль монгольских языков для алтаистических исследований*, - Altaica, Том. II, Улаанбаатар, 2002, стр. 25-44; А. А. Бурыкин, *Монгольские и тюркские заимствования в образцах малого чжурчжэньского письма*, - Altaica, Том. III, Улаанбаатар, 2003, стр. 39-66.

хэлзүйн хувьд зохисгүй гэж үзэх нь ч бий. Нарийвчилан үзвэл дотороо учир ялгаатай, хоёр өөр бүтэцтэй ажээ. *Нягтлан* гэдэг үг нь *нягтлан бодох* > *нягтлан бодогч* гэдэгийн товчилон хураасан хэлбэр тул түүнийг хам утга бүхий нөхцөл үйлийн хэлбэр гэж үзэж болно. Харин *эгшиглэн*, *залилан* гэдэг нь хоюулаа үүсэлийн хувьд хошоод ялгаа, хошоод өөр бүтэцтэй, тэр нь монгол бичигт *egesiglen – egessigleng, jalilan – jalilang* гэж хармагц ялгаатай байсан боловч шинэ үсэгээр тэр ялгаа нь гаднаасаа харагдахгүй тул одоогийн хүмүүс хам утга бүхий нөхцөл үйлийн *-н* хэлбэртэй байна гэж ганцхан хувилбараар нь ойлгоход хүрсэн ажээ. Одоогийн олонхи хүний мэдэхгүй болсон нөгөө хэлбэр нь монгол бичигт *-ng* буюу их инхлэгээр төгөсдөг бөгөөд шинэ үсэгийн дүрэмд “...*n* үсгээр хоолойн *n*, хэлний *n* хоёр дуут тэмдэглэнэ” гээд ганц үсэгээр *-н* (*-n*), *-нг* (*-ng*) хэмээх хоёр өөр авиаг ялгалгүй тэмдэглэх болгосон нь энэ бүх будлианы үүдийг нээсэн хэрэг. Тэгээд одоогийн хүмүүс *сонины*, *сонингийн*, *Цэдэний*, *Цэдэнгийн* гэдэгийн аль нь зөв болохыг ялгах аа больсон, англи хэлний *Washington*, хятад хэлний *Yang yan* гэх зэрэг *n*, *ng*-тэй бүх үгийг буруу дуудахад хүрсэн гэх зэрэг өртөөлсөн олон алдааг жагсаан үргэлжлүүлж болно. Үүнтэй адил будлиан шинэ үсэгийн “*хоолойн г*, *хэлний г*” гэдэгт бас хамаарна<sup>11</sup>. Одоо манайд хэрэглэж буй одоогийн дүрэмд л уг хоёр авиаг нэг үсэгээр тэмдэглэсэнээс биш Энэдхэг-европ хийгээд Алтай овогийн бусад хэлнээ цөмд нь (жишээ нь: англид *n/ng*, казахад *н / н, г / г* гэх мэтээр) ялган тэмдэглэдэг. Монгол бичигт ч мөн л тэр мэт ялган бичдэг байсан билээ.

Бүр яргуулан үзвэл: *эгшиглэн* < *эгшиглэн(г)*, *залилан* < *залилан(г)* гэх зэрэг үгийн тухайд эцэст байгаа ганц *-н(г)*-ийг тусад нь авч үзэх биш, *жарга-* > *жаргалан(г)*, *шанала-* > *шаналан(г)*, *хөргө-* > *хөргөлөн(г)*, *зово-* > *зовлон(г)* гэх зэрэг өдий төдий үгийн үйлээс нэр үүсгэх *-лан(г)*<sub>4</sub> дагаварын талаар авч үзэх хэрэгтэй болно. Бас үүгээр зогсохгүй *эгшиг* + *лэ-* гэх мэтээр нэрээс үйл үгийн үндэс үүсгэдэг *-ла-*<sub>4</sub> дагаварын дараа орж дахин нэр үг үүсгэдэг *лан(г)*<sub>4</sub> дагаварын нийлэц хийгээд уг нийлэц хэл бүрт нийтлэг байдаг оросоор *ганпология*, англиар *haplology*, францаар *haraxépie* гэдэг *давхацсан ижил авиа* буюу *үе гээгдэх хуулиар хэрхин хувирах явцыг давхар анхаарах ёстой* болно. Бид энэ удаад зорилгодоо нийцүүлэн үйлээс нэр үг үүсгэдэг *-лан(г)*<sub>4</sub> дагаварыг *давхацсан ижил авиа* буюу *үе гээгдэх ёсон*-той холбон авч үзэе. Хэлний хөгжилийн энэхүү ёсны үр дүн нь ил харагддаггүй боловч онолын үүднээс тодруулах бүрэн боломжтойг олон хэлний баримт нутлана. Тухайлбал: англи хэлний *England* гэдэг үг нь түүхэн үүднээс *Angle(s)* + *lond* ‘нутаг, орон’ гэсэн хоёр үгийн нийлбэр бөгөөд дараалан орсон ойролцоо дуудалга бүхий *-le-*, *lo-* гэдэг үеийн нэг нь орхигдож уламаар одоогийн *England* гэдэг үг бүтсэн ажээ. Франц хэлнээ *morpho-* + *phonologie* гэдэг хоёр үг нийлэхдээ дараалан орсон *-pho-*, *pho-* хэмээх хоёр үеийн нэг нь хураагдаж хэлшинжлэлийн *morphonologie* гэдэг нэр томъёо гарсан гэнэ. Орос хэлнээ *знамено* + *носец* гэдэг хоёр үг нийлэх тохиолдолд дараалан орсон хоёр *-но-* үеийн нэг нь хураагдан *знаменосец* гэдэг хэлбэр буй болсон байна.

Ийнхүү авч үзэх нь орчин цагийн монгол хэлний маргаантай буюу эргэлзээтэй асуудалыг зөв шийдэн таних бололцоог олгоно. Тухайлбал: үйлээс үүссэн гэж үзэж болохуйц *жаргалан(г)*, *зовлон(г)* хийгээд нэрээс үүссэн гэж үзэж болохуйц *тариалан(г)*,

<sup>11</sup> Ц. Дамдинсүрэн, *Монгол шинэ үсгийн товч дүрэм*, Улаанбаатар, 1946, 15-р тал (Чухамдаа “*хамарын н*, *хэлний н*; *хоолойн г*, *хэлний г*” гэдэг нэр томъёо хэлшинжлэлд огт байдаггүй. Учир нь хамар оролцоод хэл оролцдоггүй, эсвэл хэл оролцоод хамар оролцдоггүй “*н*”, хэл оролцдоггүй зөвхөн хоолой оролцдог “*г*” авиа гэж ерөөсөө байдаггүйг хэлшинжлэл, авиазүйн наад захын боловсролтой хүн болгон мэднэ дээ, уг нь).

хүрээлэн(г), гэдэг хошоод жишээг гаднаас нь үзвэл *лан(г)*<sub>4</sub> дагавар нь үйл болон нэр үндэсийн хойно аль алинд нь ордог мэт харагдаж болох ч чухамдаа ийм үү? эсбөгөөс хэлний дотоод хөгжил буюу ил үл харагдах далд хөгжилийн үр дүнд зөвхөн үйл үгэнд залгадаг, нарийн тогтолцоотой байж болохыг ч бас үгүйсгэх аргагүй. Ингээд дээрхи дөрвөн үг хэрхин үүссэнийг *ганолог* хэмээх *давхацсан ижил авиа* буюу *үе гээгдэх ёсон*-ы үүднээс тодруулбал:

1. Mo. *jiry-* + *lang* > *jiryalang*;  
Mo. *joba-* + *lang* > *jobalang*;
2. Mo. *tariy-a* + ([*la-* + *lang*] > *lang*) > *tariyalang*;  
Mo. *küriy-e* + ([*le-* + *leng*] > *leng*) > *küriyeleng*

гэж хос хосоороо хоёр өөр замаар үүссэн хэмээн үзэх тогтолцоот боломж харагдана.

Энд нэгэн зүйлийг тэмдэглэхэд: нэр үг бүтээдэг *-lang*<sub>2</sub> дагавар нэр үндэсийн хойно орсон мэт харагдах тохиолдолд завсарт нь тухайн нэрийг үйл болгох *-la*<sub>2</sub> дагавар давхар шаардагдаж, тэр нь авиазүйн далд хуулиар ил гарахгүй байгааг харж болно. Ингэж үзэх бөгөөс монгол хэлний *-lang*<sub>2</sub> дагавар нь зөвхөн үйлээс нэр үг үүсгэх үүрэгтэй хэмээн тодруулах боломж гарч байна.

*Haplology* хэмээх *давхацсан ижил авиа* (буюу *үе*) *гээгдэх ёсон* нь дээр дурдсан жишээнд хамаараад зогсохгүй, **эсрэг тохиолдлоор нь шинэ үсэгийн дүрэмээр хэрхин зөв бичих нь маргаантай, монгол хэлний бүтэцийг эвдэж байгууллага, явууллага, тооллого ...** гэж бичих дүрэмтэй олон үгийн бодот бүтэцийг тодруулж монгол хэлний хөгжилийн зүй тогтоолоор тайлбарлан, зөв хэлбэрийг сэргээх, тайлбарлах боломжийг олгоно<sup>12</sup>. Дурдсан гурван жишээ нь шинэ үсгээр гаднаасаа нэг тогтолцоотой мэт харагдах боловч, чухамдаа монгол хэлний зүйгээр

1. *bayi-γul-* + (*u*)*lγa*,  
*yabu-γul-* + (*u*)*lγa*
2. *toga-la-* + *lγa*

гэж бүтэцийн хувьд учир ялгаатай үүссэнийг илэрхийлж чадаагүйн дээр монгол хэлний тодорхой бүтэц бүхий *-lγa*<sub>2</sub> хэмээх ганц дагаварыг *-лга*<sub>2</sub> / *-лага*<sub>2</sub> / *-лаг*<sub>2</sub> болгон арваад салбарлуулан эвдэхэд хүргэсэн ажээ<sup>13</sup>. Дээрхи жишээг бичигт баригдалгүй чөлөөтэй дуудах явцад, ялангуяа эхиний хоёр жишээг *байгуулга, явуулга* хэмээн дуудаж байгаа нь мөнөөхи *давхацсан ижил авиа* (буюу *үе*) *гээгдэх ёсон*-той холбоотой болохыг гэрчилнэ. Энэ бүхэн нь үйлээс нэр үг үүсгэх *-lang*<sub>2</sub> дагаварын дээрхи тайлбарыг давхар батлаж өгнө.

Энэ хэсэгт өгүүлсэн баримт нь зөвхөн монгол хэлний төдийгүй, хэл бүрийн хөгжилийг судлахад хэлний ил бус, далд хөгжилийн зам чийр, түүний үр дүнг нарийвчилан үзэхийн чухалыг харуулж байна. Бид хэлшинжлэлийн салбарт онол үздэг, тэрхүү үзсэн шинжлэх ухааны жинхэнэ онолоо зохих зохих зүйлд нь, ялангуяа хэлний

<sup>12</sup> Ц. Шагдарсүрэн, *Эх хэлээ эвдэхгүй юм сан*, Улаанбаатар, 2007, 162 – 164.

<sup>13</sup> Ш. Чоймаа нар, *Монгол бичгийн хэлний тонгоруу толь*, I / II боть, Улаанбаатар, 2005, Хөх хот, 2006, VI – VII тал.

дотоод хөгжилийн эчинээ хувиралыг сэргээн тодруулахад эс хэрэглэх бөгөөс тийнхүү онол үзэхийн хэрэг юун билээ. Тэгэхдээ улс төржисөн онол бол хэрэггүй, шинэ юм гарах ч үгүй.

5. Монгол бичигийн хэлний  $V+yi+C / CV +yi+ C$  бүтэцийг галиглаж ирсэн байдалыг харахад эр үг дээр ямар нэгэн будлиангүй цөм дараахи маягаар

ᠠᠶᠢᠯ	<i>ayil,</i>	ᠪᠠᠶᠢᠨ	<i>bayin-a,</i>
ᠠᠶᠢᠮᠦ	<i>eyimü,</i>	ᠲᠡᠶᠢᠮᠦ	<i>teyimü</i>
ᠤᠶᠢᠷ	<i>oyir-a,</i>	ᠭᠣᠶᠢᠨ	<i>qoyin-a,</i>
ᠤᠶᠢᠳᠠᠷ	<i>uyidqar,</i>	ᠲᠤᠶᠢᠯ	<i>tuyil</i>

гэж галигладаг боловч үгийн эхинд болон тэргүүн үед нь *ü* эгшиг байх тохиолдолд бичилгээс үүдүүлэн гурван янзаар дараахи байдлаар

- I.   ᠠᠶᠢᠯ   *üyle,*   ᠵᠢᠶᠢᠯ   *jüyl;*
- II.   ᠠᠶᠢᠮᠦ   *üile,*   ᠵᠢᠶᠢᠯ   *jüil;*
- III.  ᠠᠶᠢᠮᠦ   *üile,*   ᠵᠢᠶᠢᠯ   *jüyl*

хэмээн галиглаж түүнийгээ өөр өөрийнхөөрөө тайлбарласан нь буй.

Энэ бүхэнийг хэлний төвшин төвшинд нь эргэцүүлэн үзэж гэмээ нь олон зүйл тодорч хэлшинжлэлийн хувьд нэгэдмэл бөгөөд зөв шийдэлд хүрэх бололцоог олгоно.

5. 1. Эхиний буюу [ᠠᠶᠢᠯ *üyle,*   ᠵᠢᠶᠢᠯ *jüyl*] хэмээн галигласан нь хэлийг бүх төвшинд тогтолцоотой гэдэг зарчмыг баримтлаж, хэлний хөгжилийн шат шатны онцлог буюу цаг хугацааны хамааралыг зөв тооцсонтой холбоотой. Үүнийг задлан тайлбарлая.

*Юуг бодолцсон бэ?*

Хэлбэр судлал буюу үгзүйн төвшинд, үг бүтээх *-yi-* дагаварыг бүх нөхцөлд *-yi-* хэлбэрээрээ байна гэж үзсэн нь залгамал хэвшинжтэй монгол хэлний онцлог буюу үгийн үндэс, язгуур, дагавар, нөхцөл тогтмол байдаг онцлогтой яг тохирч байгаа юм.

Авиазүйн төвшинд, ийнхүү үзсэн нь монгол хэлний хөгжилийн эртний үед үүсмэл урт болон хос эгшиг үүсч амжаагүй гэдэг онцлогийг давхар харгалзсан гэсэн үг.

Үсэгзүйн төвшинд, дараалан орох ёстой гурван “шилбэ”-ийг арвилан хэмнэх зарчимаар хоёроор тэмдэглэсэн үсэгзүйн шийдэлийг зөв ойлгосон байна.

Товчоор хэлбэл, ийнхүү тэмдэглэсэн нь монгол хэлний хэвшинж, түүхэн хөгжилийн үе шатны онцлогийг зөв тусгасан гэж хэлж болно.

5. 2. Хоёрдугаар буюу [ᠠᠶᠢᠮᠦ *üile,*   ᠵᠢᠶᠢᠯ *jüil*] хэмээн галигласан тохиолдолыг задлан тайлбарлахыг хичээе.

*Юуг бодолцсон бэ?*



Үсэгзүйн төвшинд, дараалан орсон хоёр шилбийн эхинийхийг үгийн эхиний болон тэргүүн үеийн *й*- эгшигийнхи, хоёрдахийг нь *-i*- эгшигийнхи гэж үзсэнтэй холбоотой.

Авиазүйн төвшинд, эртний монгол хэлнээ эм үгийн эхинд болон тэргүүн үед *йi*- / *-йi*- хос эгшиг байсан гэдэг дүгнэлт гарна.

Хэлбэр судлал буюу үгзүйн төвшинд, эртний монгол хэлний харьцангуй хожуу үеийн дурасхал болдог монгол бичигийн хэлний үг бүтээх *-yi*- дагавар нь эр үгэнээ *-yi*, эм үгэнээ *-i*- хэлбэртэй болдог гэж үзсэн хэрэг.

*Юуг бодолцсонгүй вэ?*

Үсэгзүйн төвшинд, гурав дараалан орох ёстой байсан “шилбэ”-ийн нэгийг нь арвилан хэмнэж хоёроор тэмдэглэсэн үсэгзүйн боломжийг анхаараагүй;

Авиазүйн төвшинд, эртний монгол хэлэнд үүсмэл урт хийгээд хос эгшиг үүсээгүй гэдэг үзэл баримтлалыг хайхараагүй;

Хэлбэр судлал буюу үгзүйн төвшинд, залгамал хэв шинжтэй монгол хэлний хөгжилийн эртний үед үг бүтээх *-yi*- дагавар эр, эм аль ч үгэнд *-yi*- гэдэг ганц хэлбэртэй байсан гэдгийг үл зөвшөөрсөн;

5. 3. Гуравдугаар буюу [ᠶᠢᠯᠢᠰᠢ / *üile*, ᠵᠢᠶᠢᠯᠢ / *jüvil*] хэмээн галигласаны цаад учир шалтгааныг задлан тайлбарлахыг хичээе.

*Юуг бодолцсон бэ?*

Энэ тохиолдолд тухайн хоёр жишээг тус тусад нь тайлбарлах шаардалга гарна. Үүнд: [ᠶᠢᠯᠢᠰᠢ / *üile*] гэж галигласан эхиний үгийн тайлбар нь хоёрдугаар тохиолдолын бүх тайлбартай тохирно. Харин [ᠶᠢᠯᠢᠰᠢ / *üile*] гэж галигласан аталаа [ᠵᠢᠶᠢᠯᠢ / *jüvil*] хэмээн галигласан нь нэгдүгээр тохиолдолын тайлбартай гадна талаасаа адил мэт харагдавч уг сэдэл нь огт өөр гэж үзэх үндэс бий.

Энэ нь олонхи тохиолдолд үгийн дунд орсон *ö* / *ü* эгшиг зөвхөн гэдэс хэлбэртэй байна гэж монгол бичиг заахад тайлбарладагтай холбоотой. Гэтэл уг хоёр эгшиг үсэг гийгүүлэгчээр эхлэсэн үгийн тэргүүн үед [CV<sub>=ö/ü</sub>] тохиолдвол, ᠶᠢᠯᠢᠰᠢ / ᠵᠢᠶᠢᠯᠢ гэх мэтээр гэдэс + шилбэ гэсэн хоёр махбодтой, харин хоёрдугаар үеэс эхлэн ганц гэдэс болдог зүй тогтол монгол бичигт байдаг билээ. Зүй нь монгол бичиг заахад *ö* / *ü* эгшигийн тухайд *үгийн эхинд*, *үгийн нэгдүгээр үед*, *нэгдүгээр үеэс хойшид* гурван өөр хэлбэртэй болдогийг марталгүй анхаарах хэрэгтэй байсан бөлгөө. Иймээс тухайн галиглагч ᠶᠢᠯᠢ гэдэг үгийн гутгаар махбод – *шилби*-ийг *ü* эгшигт хамаарахгүй гэж үзсэн тул *jüvil* хэмээн тэмдэглэсэн хэрэг.

*Юуг бодолцсонгүй вэ?*

Энд 5. 2.-т дурадсан юуг бодолцсонгүй вэ? гэдэгийн тайлбартай адилхан тул түүнээс эргэн үзэхийг хүснэ. Дээр нь сая дурадсан *ö* / *ü* эгшиг үгийн эхинд, тэргүүн үед, түүнээс хойш орохдоо гурван өөр хэлбэртэй болдогийг нэмэн бодолцох шаардалгатай болно.

Энэ мэтээр аливаа үсэгзүйн төвшинд бичилгэ хялбарчилдаг зарчим буй бөгөөд монгол бичигт гурван шилбэ давхарлах тохиолдолд хоёроор тэмдэглэсэн, монгол дөрвөлжин бичигт гийгүүлэгч зохицох ёсоор эм эгшигийн нийлмэл бүтэцийг товчилож эр эгшиг мэтээр бичдэг зэрэг түгээмэл зарчим бусад улсын бичигт ч байдагийг мартах аргагүй.

Энэхүү тавдугаар хэсэгийн эцэст, II (5.2), III (5.3) тохиолдолын талаар саналаа товч хэлэхэд:  $V_{=i}+yi+C / CV_{=i}+yi+ C$  бүтэцийг тийнхүү янз янзаар тэмдэглэж байгаа нь монгол бичигийн хэлний тухайн үеийн онцлогийг сэргээх зорилго бүхий зөв дуудалгын галиг (transcription)-ийг үсэгийн галиг(Transliteration)-ийн зарчимтай хутгаж дуудалгын галигийг үсэгийн галигийн үүргээр хэрэглэсэн гэж үзэхэд хүргэж байгаа юм. Энэ нь цаанаа тухайн хүн, монгол бичигийн хэлний тухайн үеийнхи нь онцлогийг харгалзалгүй, өнөөдөрийн монгол хэлний мэдэлгэдээ ойртуулан авч үзсэнтэй давхар холбоотой.

Монгол бичигийн хэлний үг үүсгэх *-yi-* дагавар нь авиазүйн төвшинд, хос эгшиг бололгүй, харьцангуй сүүл үе болтол энэ хэлбэрээрээ байсаныг "Монголын нууц товчоон", Юан болон Мин Улсын үед хятад үсэгээр тэмдэглэсэн монгол хэлний хэрэглэгдэхүүн<sup>14</sup>, араб үсгээрхи монгол хэрэглэгдэхүүн, соёмбо, хэвтээ дөрвөлжин, тод бичигийн хэрэглэгдэхүүн цөм нутладаг<sup>15</sup>. Нэгэнт ийм бөгөөтөл тэдэнтэй харьцуулахад хамаагүй түрүү үеийн буюу эртний монгол хэлний баримт дурасхал болдог монгол бичигийн хэлний хэрэглэгдэхүүнийг өдгөөгийн монгол хэлний үзэмжээр хос эгшиг байсан мэтээр үзэх аргагүй.

6. Монгол хүний уугуул сэтгэлгээ болон монгол үнэлэмжийг тээж ирсэн мянга гаруй жилийн уламжлалтай монгол бичигээ сайн мэдэх, зөв ухаарах, зөв тайлбарлах явдал нь зөвхөн хэлний мэргэжилтэний хэрэг огт биш, уг нь бүх монгол хүнд тэгш хамаарах зүйл бөлгөө. Үүний дээр уг бичигээр уламжлан ирсэн, тухай тухайн цагийнхаа хүмүүн төрөлхитөний оюун мэдэлгийн сорьг багтаасан олон мянган боть номын баримт агуулагдахууныг улс төрийн учир холбогдолоор "мартах", мартуулах, үгүйсгэх, үл тоон орхигдуулах арга үгүй.

Нэгэн зүйлийг энд холбогдуулан тэмдэглэхэд: монгол хүн монгол бичигээ мэдэхгүй болсоноор монгол хэлээ ч ойлгохоо болисоныг манай зарим томоохон эрдэмтэн 1246 оны албан бичиг дээрхи Монгол Төрийн тамгын "алдахуй" гэдэг үгийг "алдахгүй" гэж бүр эсрэгээр нь ойлгож олон боть "Монголын түүх"-эндээ тайлбарласанаас үзэж болно... Хэрэвзээ монгол хэл сайн мэдэхгүй гадаадын хүн ингэж ойлгосон байлаа ч өөрийнхөө түүхийг бичиж байгаа монгол хүн зөв болгон засан тайлбарлах ёстой биш үү. 1940-өөд он болтол шинжлэх ухаан-ыг шинжилэхүй ухаан гэж хэлдэг бичдэг байлаа, өрнө зүгийг наран шингэхүй зүг, дорно зүгийг наран ургахуй зүг гэдэг байсаныг дээрхи жишээгээр авч үзвэл шинжлэх ухааныг шинжлэхгүй ухаан, баруун зүгийг наран шингэхүй зүг, зүүн зүгийг наран ургахүй зүг гэхэд хүрэх нь.

<sup>14</sup> 方龄贵 (Fang Ling-gui), *元明戏曲中的蒙古语 (Mongolian Expressions in Yuan and Ming Dramas)*, 上海, 1990; 方龄贵 (Fang Ling-gui), *古典戏曲外来语考释词典 (A Dictionary of Loanwords in Classical Dramas of China)*, 汉语大词典出版社, 云南大学出版社, 上海, 2001, p. 566-b....

<sup>15</sup> Ц. Шагдарсүрэн, *Монгол бичигийн хэлний [V+yi+C / CV +yi+ C] бүтэцийг галиглах асуудалд* - Дундад Улсын Монгол судлалын Олон улсын ярилцах хурал (2005 оны 8-р сарын 19-23, Хөх хот)-д зориулж бичсэн илтгэл - *Үндэсний монгол судлал*, N. 6, 2005, Улаанбаатар, 34-37-р тал; Ц. Шагдарсүрэн, *Эх хэлээ эвдэхгүй юм сан...*, Улаанбаатар, 2007, 162-163, 166-167-р тал.

Монгол бичигийн хэл бол Эртний монгол хэлний хөгжилийн харьцангуй хожуу үеийн онцлогийг хадгалсан гэдэг нь тодорхой бөгөөд Дундад үеийн монгол хэлний хэрэглэгдэхүүнтэй харьцуулж гэмээ нь тодорхой харагдана... Гэвч нэг бус судлагч одоогийн байдлаар монгол бичигээрхи дурасхалын олдоц нь цаг үеийн хувьд монгол хэлний хөгжилийн дундад үетэй давхацдагаар нь монгол хэлний Дундад үеийн онцлогтой, дундад үеийн дурасхал гэж үзсэн нь буй<sup>16</sup>. Хэдийгээр Чингисийн чулууны бичиг, Европ дахинд уг эхээрээ хадгалагдаж буй Ил хаадын албан захидал тэргүүтэн нь цаг хугацаа хийгээд утга агуулгын хувьд XIII-XVI зуунд хамаарч байгаа боловч (бичигийн) хэлний хувьд энэ үед холбогдохгүй. Энэ нь англи бичигийн хэлээрхи зүйлийг үзээд бичилгэ, дуудалга үлэмж зөрөөтэйг нь үл харгалзан өнөөдөрийн англи хэлний баримт гэж болдоггүйтэй нэгэн адил. Тэр хүмүүс монгол бичигийн дурасхалыг ийнхүү дундад үед хамааруулан үзэж байгаа нь нэгд, тэд нар монгол бичигийг XIII зуунд Уйгураас авсан тул тэр үеийнхээ монгол хэлний онцлогийг тугасан байх ёстой гэдэг үзэл бодолоос нь, хоёрт, монгол бичигийн хэлний байдалыг огт мэддэггүйтэй нь, мөн монгол бичигийн хэлийг дундад үеийн монгол хэлний баримт хэрэглэгдэхүүнтэй харьцуулан үзээгүйтэй нь шууд холбоотой. Өөр нэг баримт гэхэд, 925 оны хятан “бага” бичигийн хэлбэрийн тухайд зарим судлагч уйгур үсэгтэй ойролцоо байх ёстой гэж таамагласан нь нэгд, түүхэн сурвалжид уг бичигийг зохиосон гэж үздэг Елүй овогийн Де-ла гэгч түшмэл Ляо Улсад Уйгураас ирсэн элчийг угтаар очин биеэр дагалдан бараг сар шахам хамт явахдаа тэдний хэл бичигийг сурсан гэдэг мэдээг харгалзан тооцсон, хоёрт, тухайн бичигийн дурасхалыг үзээгүйтэй давхар холбоотой буй заа.

Энэ мэтээр тухайн зүйлийн мөн чанарыг нь үл анхаарч нэр болон өөрийн дотоод итгэл үнэмшилдээ хөтлөгдөж наагуурхан ойлгож тайлбарлах явдал цөөнгүй тохиолддог. Тухайлбал: *Сонгодог монгол бичигийн хэл* гэдэг нэр томъёоноос үзэхэд *сонгодог хөгжим*, *сонгодог зураг* гэдэг жишигээр бүх талаараа ямар ч өөгүй мэтээр олон хүн ойлгодог боловч, XVI зууны үед шашин сурталын бүх салбарын хөлгөн судар, шаштар тэргүүтэний монгол орчуулгыг багтаасаны хувьд буюу соёлын хүрээнээ тийнхүү *сонгодог* хэмээн үзэж болох боловч, төвөд хэлзүйн нөлөө үлэмж туссаны учир монгол хэлний зүй, найруулгын үүднээс тэрхүү *сонгодог* гэдэг тодотголыг хүлээн зөвшөөрөхөд учир дутагдалтайг эл өгүүлэлийн зохиогч хэдэн жилийн өмнө хөндөн ярьсан билээ<sup>17</sup>.

Жишээ баримтын төдий товчхон өгүүлсэн дээрхи зүйлийг цаашидын судлагаанд бодолцож гэмээ нь монгол хэлний эрт өдгөөгийн мөн чанарыг улам тодруулаад зогсохүй Алтай овог хэлний харьцуулсан судлагааг ч нэг бус талаар өргөтгөх боломжийг олгоно хэмээн итгэж байна.

<sup>16</sup> С. А. Крылов, *Теоретическая грамматика современного монгольского языка, и смежные проблемы общей лингвистики*, 1, Москва, 2004, 480 стр, см. 274-275.

<sup>17</sup> Ts. Shagdarsureng, [古典式モンゴル文語あるいはモンゴル經典言語の若干の特徴について] *The Classical Mongolian or Mongolian Sutra Language and its Stylistic Feature* - Bulletin of Japanese Association for Mongolian Studies, No. 32 (2002), pp. 41-53 ( Японоор орчуулсан Mukai Shin'ichi); Ц. Шагдарсүрэн, *Сонгодог монгол бичигийн хэл буюу монгол сударын хэлний онцлогоос*, - *Acta Mongolica*, [Centre for Mongol Studies, Nat. Univer. of Mongolia], Tom. 2 (208), Ulaanbaatar, 2003, 17-30-р тал; Ц. Шагдарсүрэн, *Эх хэлээ эвдэхгүй юм сан...*, Улаанбаатар, 2007, 162-163, 110-113-р тал.

## ABSTRACT

The author underlines the importance of the following principles regarding the methodology of the researches on historical linguistics illustrating his ideas on the concrete data of both Mongolian and other Altaic languages:

- In the comparative studies of the scripts not only the external form likeness must be taken into account, but also the internal contest and philosophical background have to be considered as well.
- A study of common-root words in relative languages belonging to the same ethnic group can not be limited by entry words in translational dictionaries, as an additional criteria a semantic field has to be taken into account.
- In a comparative study of languages the shades of differences in such aspects as common-root words, forms having the same origin, but developed independently and in parallel, loan-words, accidental similarities and so on have to be clarified.
- In accordance with the principle "A language is a system" every aspect of a language has to be considered in its own level distinguished from the other similar ones.
- To be always aware of "the principle" that the structure of a Mongolian word never can be explained according to the Cyrillic orthography, where the typological peculiarities of the Mongolian language are reflected by no means correctly unlike the literary Mongolian language presenting the samples of the Mongolian type of thinking.

*This work is dedicated to the memory of professor E. R. Tenishev (1921-2004), turcologist of Russian Federation.*